

Онцгой байдлын ерөнхий газрын даргын зөвлөлийн 2020.01.03-ны өдрийн 01 дүгээр хуралдааны шийдвэрээс:

1.1. Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд ОББ-аас хэрэгжүүлэхээр тусгасан арга хэмжээний хэрэгжилтэд 2019 оны жилийн эцсийн байдлаар хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн тухай хэлэлцээд дүнг 100,0 хувьтай батлав.

1.2. “Монгол Улсын Эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх Үндсэн чиглэл”-д ОББ-аас хэрэгжүүлэхээр туссан зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд 2019 оны жилийн эцсийн байдлаар хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн дүнгийн тухай хэлэлцээд дүнг 92,5 хувийн үнэлгээтэйгээр батлав.

1.3. ОББ-аас хэрэгжүүлж буй хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтэд 2019 оны жилийн эцсийн байдлаар хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн дүнгийн тухай хэлэлцээд дүнг 94,0 хувьтай батлав.

1.4. ОБЕГ-ын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн дүнгийн тухай хэлэлцээд дүнг 98,5 хувийн үнэлгээтэйгээр батлав.

1.5. “Гурван тулгуурт хөгжлийн бодлого”-ыг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд ОББ-аас хэрэгжүүлэхээр тусгасан арга хэмжээний хэрэгжилтэд 2019 оны жилийн эцсийн байдлаар хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн дүнгийн тухай хэлэлцээд дүнг 100 хувийн үнэлгээтэй батлав.

1.6. ОБЕГ-ын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний төслийн тухай хэлэлцээд 01 дүгээр сарын 06-ны дотор бэлэн болгохыг даалгав.

1.7. ОБЕГ-ын 2020 оны бие бүрэлдэхүүний сургалт бэлтгэлийн нэгдсэн төлөвлөгөөний төслийн тухай хэлэлцээд 01 дүгээр сарын 06-ны дотор холбогдох засвар өөрчлөлтийг тусган батлуулахыг даалгав.

---oOo---